

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчимд холбогдох шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ*

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ДЭРГЭДЭХ
ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ*

* Энэхүү дүн шинжилгээ нь Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн албан ёсны цахим хуудаст 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр нийтлэгдсэн болно.

* Энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээг Шүүхийн академийн Шүүхийн судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн (Ph.D) удирдан, Захиргааны эрх зүйн секторын судлаач О.Тэнхлүүн хийж гүйцэтгэв.

УДИРТГАЛ

Төрийн үйл ажиллагаа нь зөвхөн хуульд захирагдах төдийгүй иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг зөрчихөөс сэргийлэхийн зэрэгцээ тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой байх учиртай. Энэ хүрээнд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь захиргааны байгууллагын шийдвэр үйл ажиллагаанд хяналт тавих чухал шалгуур болж өгдөг.

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь төрийн байгууллагаас өмнө гаргасан шийдвэр, өгсөн баталгаа, тогтвортой үйл ажиллагаа дээр үндэслэн иргэн, хуулийн этгээд тодорхой итгэл үнэмшил төрж, түүндээ нийцүүлэн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд уг итгэлийг үндэслэлгүйгээр зөрчих, хохироохгүй байх шаардлагыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллагын дур зоргыг хязгаарлаж, иргэний итгэлд суурилсан эрх зүйн хамгаалалтыг бий болгох үүрэгтэй.

Энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээгээр хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын ойлголт, эрх зүйн зохицуулалтыг тодорхойлон тайлбарлаж, шүүхийн практикт уг зарчим хэрхэн хэрэгжиж байгааг тодорхойлохыг зорилоо.

НЭГ. ТАНИЛЦУУЛАХ ХЭСЭГ

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2024/0077

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан.

Хэргийн тухай товч:

Баянгол дүүргийн Засаг даргын 1999 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Б/43 дугаар "Газрын зөвшөөрөл олгох тухай" захирамжаар нэхэмжлэгч Ж.Н-т Баянгол дүүргийн 01 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 24 м.кв бүхий талбайд павильон барих зөвшөөрөл олгож, газар эзэмших ашиглах гэрчилгээг дөрвөн жилийн хугацаатай олгож, газрын төлбөрийг дүүргийн газрын санд төлүүлэхээр шийдвэрлэжээ.

Дээрх шийдвэрийг үндэслэн нэхэмжлэгч Ж.Н нь 2003 оны 07 дугаар сарын 15-ны өдөр Баянгол дүүргийн Хот байгуулалт, газрын харилцааны албатай /хуучин нэрээр/ 36м.кв газар ашиглах гэрээ байгуулан 2004 оны 07 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл улирал тутам сунган ашиглаж байгаад Баянгол дүүргийн Засаг даргын 2004 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 256 дугаар захирамжаар тус гэрээг тодорхойгүй хугацаагаар сунгасан байна.

Үүний дараа 2004 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр 8010/5028 дугаар бүхий Газар эзэмшүүлэх гэрээг байгуулан тус гэрээг 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгажээ. Нэхэмжлэгчээс 2008 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Баянгол дүүргийн Газрын албаны даргад хандан гэрээний хугацааг сунгуулах өргөдөл гаргаснаар жил бүр газрын төлбөр тогтоосон акт үйлдэн тооцоо нийлж,



баталгаажуулж явсаар 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдөр 2020 оны газрын төлбөрийг бүхэлд нь төлж 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл газар ашиглах хугацааг тогтоосон байна.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 2014 оны 07 дугаар сарын 10-ний өдрийн 01–01/05 дугаар ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдсон нийтийн орон сууцны барилгуудын ашиглалтыг хориглож шийдвэрлэжээ.

Уг шийдвэрийн дагуу нийслэлийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/736 дугаар захирамжаар Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх ашиглалтын шаардлагыг шаардлага хангахгүй болсон, нийтийн зориулалттай орон сууцны 11, 12 дугаар байрны барилгажилтын төслийг боловсруулж хэрэгжүүлэх эрхийг "Т" ХХК-д олгож, нийслэлийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 100 дугаар захирамжаар 3522 м.кв газрыг тус компанид эзэмшүүлсэн байна. Мөн Т ХХК-д Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны *****, ***** дугаар байруудыг буулган 2948,2 м.кв эдэлбэр газрын 2088,4 м.кв барилгажих талбайд орон сууц, үйлчилгээ, контор, зочид буудлын зориулалтаар 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр ГБМЗХ2020/0542 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгаврыг¹ Хот байгуулалт, хөгжлийн газраас олгосон байна.

Нэхэмжлэгч Ж.Н-ын ашиглаж байсан гэх газар нь дээрх барилгажилтын төсөл хэрэгжүүлэх газартай давхцалтай болох нь тогтоогдсон. Нэхэмжлэгч Ж.Н-ээс 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр нэхэмжлэгч Баянгол дүүргийн Засаг дарга С.О-д хандан улмаар Баянгол дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дэргэдэх Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөл 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хуралдаж нэхэмжлэгчийн хүсэлтийг хэлэлцээд эс зөвшөөрсөн шийдвэр гарснаас нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгчийн зүгээс Баянгол дүүргийн Засаг даргад холбогдуулан Баянгол дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/35 дугаар захирамжийг хууль бус байсан болохыг тогтоолгох, уг захирамжийн улмаас учирсан хохирлыг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлснийг тус шүүхийн 2023 оны 04 дүгээр сарын **-ний өдрийн 3281 дүгээр захирамжаар хүлээн авч шийдвэрлэсэн.

Иймд нэхэмжлэгч Ж.Н-ээс:

1. Баянгол дүүргийн Газар зохион байгуулах албаны дэргэдэх газар эзэмших ашиглах эрхийн хянан шийдвэрлэх дэд зөвлөлд холбогдуулан 2020 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 05 дугаартай тэмдэглэл болон дүгнэлтийг хууль бус болохыг тогтоолгож хүчингүй болгуулах;
2. Баянгол дүүргийн Газар зохион байгуулах албанд холбогдуулан Баянгол дүүргийн Газар зохион байгуулах албаны 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 12/1403 тоот албан бичгийг хууль бус болохыг тогтоолгож хүчингүй болгуулах;

¹ Уг даалгавар нь Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/977, 2017 оны А/736 дугаар захирамжуудыг хэрэгжүүлэхээр олгогджээ.

3. Баянгол дүүргийн Засаг дарга болон Газар зохион байгуулалтын албанд холбогдуулан гаргасан Газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгаж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгохгүй байгаа хариуцагчийн эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоолгож, гэрчилгээг сунгаж нөхөн олгуулах, нэхэмжлэгчтэй газар эзэмших гэрээ байгуулахыг даалгах;
4. Баянгол дүүргийн Засаг даргад холбогдуулан гаргасан Баянгол дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/35 дугаар захирамжийг хууль бус байсан болохыг тогтоолгох, уг захирамжийн улмаас учирсан хохирлыг гаргуулах;²
5. Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газарт холбогдуулж 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн ГБМЗХ2020/0542 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгаврын Ж.Н-ын газартай давхацсан хэсгийг хүчингүй болгуулах;
6. Нийслэлийн Засаг даргад холбогдуулан Газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгаж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгохгүй байгаа хариуцагчийн эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоолгож, гэрчилгээг сунгаж нөхөн олгуулах, нэхэмжлэгчтэй газар эзэмших гэрээ байгуулахыг даалгах тухай нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлсон.

ХОЁР. ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Анхан шатны шүүх:³ Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс дараах үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож, үлдэх хэсгийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ:

1. Газрын тухай хуулийн⁴ 27 дугаар зүйлийн 27.1-д Газрыг энэ хуульд заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр зөвхөн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ, 27.4-д Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно гэж тус тус заасан; (2.7)⁵
2. Нэхэмжлэгчийн хувьд 1999 онд олгосон газрын гэрчилгээний дагуу 4 жил эзэмшсэн бөгөөд үүнээс хойш Газар ашиглах гэрээ байгуулан жил бүр сунгуулсан үйл баримт тогтоогдсон, харин газрыг хууль ёсны дагуу эзэмшээгүй. Иймд Баянгол дүүргийн Газар зохион байгуулалтын

² Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгчийн зүгээс Баянгол дүүргийн Засаг даргад холбогдуулан Баянгол дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/35 дугаар захирамжийг хууль бус байсан болохыг тогтоолгох, уг захирамжийн улмаас учирсан хохирлыг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлсэн. Учир нь А/35 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны дахин төлөвлөлтийн ажлын хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажил, авто зам, гудамж талбайн тохижилтын ажлыг эрчимжүүлэх үүднээс ... объект зөвшөөрөлгүй байрлуулсан тохиолдолд ... албадан буулгаж нийтийн эзэмшлийн зам, талбайг чөлөөлөхөөр шийдвэрлэсэн байна.

³ НдЗХАШШ-ийн 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 0139 шийдвэр, https://shuukh.mn/single_case/15113?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2025.11.18).

⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2002), № 27.

⁵ "Шийдвэрлэсэн байдал" хэсэгт бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



- албаны дэргэдэх Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөл, Баянгол дүүргийн Засаг дарга, Газар зохион байгуулалтын албанд холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэлээ; (2.8)
3. Хот байгуулалт, хөгжлийн газраас олгосон ГБМЗХ2020/0542 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар нь нэхэмжлэгчийн гэрчилгээ бүхий газартай давхцалгүй тул энэхүү шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэх нь зүйтэй; (3.2)
 4. Баянгол дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/35 дугаар захирамжийг хууль бус байсан болохыг тогтоолгох, уг захирамжийн улмаас учирсан хохирлыг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагын тухайд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3⁶-д заасан урьдач нөхцөл хангагдаагүй. (2.12) Иймд ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-т заасныг баримтлан нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж; (2.13)
 5. Хэрэгт авагдсан баримтаас үзвэл нэхэмжлэгчийн зүгээс Нийслэлийн Засаг даргад гандан газар эзэмших талаар аливаа өргөдөл, хүсэлт гаргаагүй (4.3) тул нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэлээ. (4.4)

НдЗХАШШ-ээс нэхэмжлэгч Ж.Н-ийн Баянгол дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дэргэдэх Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөл, Баянгол дүүргийн Засаг дарга болон Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газарт тус тус холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагуудыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон байна. Харин Баянгол дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/35 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын эс үйлдэхүйд холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзжээ.

Давжзаалдах шатны шүүх:⁷ Анхан шатны шүүхээс орхигдуулсан нэхэмжлэлийн шаардлага (12/1403 дугаар албан бичиг)-ыг хүлээн авахаас татгалзаж гэж нэмж дүгнэн, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон, нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхижээ. Шийдвэрийн үндэслэл:

1. Нэхэмжлэгчид 1999 онд 4 жилийн хугацаатай эзэмшүүлэх шийдвэр гаргаснаас өөрөөр уг газрыг эзэмшүүлэх, ашиглуулахаар эрх бүхий этгээдээс аливаа шийдвэр гаргаагүй, гэрээ байгуулж, гэрчилгээ олгоогүй байгаа энэ тохиолдолд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байх тул энэ талаарх нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн гаргасан гомдлыг хүлээн авах боломжгүй; (2.4)

⁶ ЗХШХШТХ (2016)-ийн 106 дугаар зүйлийн 16.3.3 "захиргааны акт хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн бөгөөд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоох;"

⁷ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 0242 магадлал, https://shuukh.mn/single_case/7892?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2025.11.18).



2. Өмгөөлөгч давж заалдах гомдолдоо "... Засаг даргын 2022 оны А/35 дугаар захирамжийг шүүх хянахгүй байх үндэслэл болохгүй" гэжээ." (2.5) ... хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн шаардлага өөрчлөх зохицуулалт хэрэгжих тул энэ талаар дүгнэсэн анхан шатны шүүхийн дүгнэлт үндэслэлтэй; (2.6)
3. ... А/736 дугаар захирамжаар Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх ашиглалтын шаардлага хангахгүй болсон, нийтийн орон сууцны 11, 12 дугаар байрны барилгажилтын төслийг боловсруулж хэрэгжүүлэх эрхийг "Т" ХХК-д олгож Нийслэлийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 100 дугаар захирамжаар 3522 м.кв газрыг тус компанид эзэмшүүлж шийдвэрлэсэн нь тогтоогдож буй энэ тохиолдолд нэхэмжлэгчийг маргаан бүхий газрыг эзэмших, ашиглах эрхтэй этгээд гэж үзэх үндэслэлгүй; (2.8)
4. Баянгол дүүргийн Газар зохион байгуулалтын албаны 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 12/1403 дугаар албан бичиг нь маргаан бүхий асуудлаар бие дааж шийдвэр гаргасан захирамжилсан шийдвэр биш, нэхэмжлэгчид эрх зүйн шууд үр дагавар бий болгоогүй байх тул захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх үндэслэлгүй юм. (2.12)

Хяналтын шатны шүүх:⁸ Гомдлын хүрээнд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж шийдвэрлэжээ. Тогтоолын үндэслэл:

1. Нэхэмжлэгч нь ... 2002 онд батлагдсан Газрын тухай хуулийн дагуу газрыг эзэмшээгүй байх тул газрын харилцааг хуульд нийцсэн гэж дүгнэх, түүнчлэн газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгах хууль зүйн үндэслэлгүй; (17)
2. Нэхэмжлэгчийн газар нь дахин барилгажилтын төсөлд хамрагдаж, мөн тухайн газар нь инженерийн шугам, сүлжээ бүхий газар байх тул газар эзэмших гэрээ байгуулахыг даалгах, давхцалтай хэсгийг хүчингүй болгуулах шаардлагыг хангах хууль зүйн үндэслэлгүй; (21)
3. Энэ хүрээнд анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийн холбогдох шаардлагуудыг хэрэгсэхгүй болгож, хүлээн авахаас татгалзаж хэргийг хэрэгсэхгүй болгосон нь үндэслэл бүхий; (22)
4. Захиргааны ерөнхий хуулийн 104 дүгээр зүйлийн 104.1-д "Захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөний улмаас хохирол учирсан бол төрөөс нөхөх олговор олгож хохирлыг барагдуулна" гэж захиргааны хууль ёсны үйл ажиллагаанаас хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн тохиолдолд нөхөн олговор олгох ерөнхий шаардах эрхийг тусгаж өгсөн; (23)

⁸ УДШ-ийн 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 0077 тогтоол, https://shuukh.mn/single_case/3273?daterange=2024-01-01%20-%202024-12-31&id=3&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2025.11.18).



5. Нэхэмжлэгч нь 1999 оноос хойш павильон барьж бодитоор ашигласан, мөн захиргаа өөрөө нэхэмжлэгчтэй газар ашиглах гэрээ байгуулан жил бүр сунгасан, газрын төлбөрийг төлүүлж байсан зэрэг нөхцөл байдал тогтоогдож байх үед нэхэмжлэгчид зохих ёсоор газрыг эзэмшиж буй гэх тодорхой итгэл үнэмшил бий болсон байх бөгөөд энэ бүх хугацаанд нэхэмжлэгчийг хууль бусаар газрыг эзэмшиж байсан гэж дүгнэх нь зүйд нийцэхгүй; (24)
6. Энэ хүрээнд анхан болон давж заалдах шатны шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3-т заасан нөхцөл байдал тогтоогдохгүй байна гэдэг үндэслэлээр нэхэмжлэлийн уг шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь буруу; (25)
7. Нэхэмжлэгч нь Баянгол дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/35 дугаар захирамж, түүнийг хэрэгжүүлж газрыг албадан чөлөөлж павильоныг буулгасан нь уг харилцааг зохицуулсан хуульд нийцсэн эсэх, мөн өөрт учирсан хохирол, нөхөн олговрын асуудлаар шаардан маргах эрхтэй; (26)
8. Нэхэмжлэгч нь эхлээд урьдчилан шийдвэрлүүлэх ажиллагааны журмаар захиргаатай харилцан тохиролцох зохицуулалттай тул "Баянгол дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/35 дугаар захирамжийг хууль бус байсан болохыг тогтоолгох, уг захирамжийн улмаас учирсан хохирлыг барагдуулах" нэхэмжлэлийн шаардлагыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн⁹ 54 дүгээр зүйлийн 54.1.3-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан өөрчлөлтийг оруулж, газрыг албадан чөлөөлсөн шийдвэр үйл ажиллагааг хянуулах эрхтэй. (27)

Анхан шатны шүүх нэхэмжлэлийн Баянгол дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/35 дугаар з

ахирамжид холбогдох хэсгийг ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-т заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан. Харин УДШ-ээс "нэхэмжлэгчид зохих ёсоор газрыг эзэмшиж буй гэх тодорхой итгэл үнэмшил бий болсон, иймд нэхэмжлэлийн уг шаардлагыг дээрх үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь буруу, А/35 дугаар захирамж хуульд нийцсэн эсэх, учирсан хохирол, нөхөн олговрын асуудлаар шаардан маргах эрхтэй" гэж дүгнэсэн байна.

ГУРАВ. ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний хүрээнд хууль ёсны итгэл хамгаалах зарчмын талаарх ойлголт буюу төрийн үйл ажиллагаанд итгэсэн иргэдийн "итгэл хамгаалах" асуудлын талаар онолын үзэл баримтлал, шүүхийн практик, гадаад улс орны эрх зүйн зохицуулалт, хууль хэрэглээг судална.

⁹ Төрийн мэдээлэл эмхэтгэл, (2016) №09.

3.1. Эрх зүйн зохицуулалт болон онолын ойлголт

"Хууль ёсны итгэлийг хамгаалах" зарчим нь Ромын эрүүгийн эрх зүйгээс үүдэлтэй бөгөөд Францийн хувьсгалын үед Пруссийн эзэнт гүрний улсуудын хуулийг батлахдаа эрүүгийн шинэ хууль батлагдахаас өмнө үйлдсэн гэмт хэрэгт тус эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэхгүй талаар зохицуулалт оруулснаар Германы эрх зүйн тогтолцоонд энэхүү зарчим нэвтрэх үндэс тавигдсан гэж үзэж болно.¹⁰

Уг зарчим нь Захиргааны эрх зүйн салбар харьцангуй өндөр түвшинд хөгжсөн улсуудад захиргааны эрх зүйн гол зарчмуудын нэг гэж үздэг бөгөөд тухайлбал судлаач, профессор Адам Перри, Парра Ахмед нар "Хууль ёсны итгэлийн сургаалын уялдаа холбоо" бүтээлдээ дурдсанаар "Төрийн байгууллага ямар нэг байдлаар өөрийн эрхээ хэрэгжүүлэхдээ таны "хууль ёсны итгэл"-ийг алдсан бол та хуулиар өөрийн итгэлийг" хамгаалуулах эрхтэй. Энэхүү "хууль ёсны итгэл"-ийн тухай сургаал нь захиргааны эрх зүйн "зүрх" нь гэгддэг билээ" хэмээн дурдсанаас уг зарчмын агуулга ач холбогдол тодорхой харагдаж байна.¹¹

Монгол Улсад 2016 онд Захиргааны ерөнхий хууль¹² (цаашид "ЗЕХ" гэх)-ийг баталснаар хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим анх хуульд тусгалаа олсон байна. ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.8-д "хууль ёсны итгэлийг хамгаалах" зарчмыг захиргааны байгууллага үйл ажиллагаандаа баримтлахаар хуульчилж өгчээ.

Хуулийн уг зүйл, заалтын тайлбарт "Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим гэж нийтийн эрх зүйн аливаа харилцаанд захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдэд эдийн буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эрх зүйн үр дагавар үүссэн тохиолдлыг ойлгоно. Харин энэ хуулийн 48.2-т заасан тохиолдол үүсвэл захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн итгэл хамгаалагдахгүй. Иргэн, хуулийн этгээдэд эерэг үр дагавар үүсэхээр байсан ч уг харилцаа дууссан бол итгэл хамгаалах зарчим хэрэглэгдэхгүй" гэжээ.

Хуулийн дээрх аутентик тайлбарыг үндэслэн судлаачдын зүгээс¹³ "хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим"-ыг хангахын тулд дараах урьдчилсан нөхцөлүүд хангагдсан байх ёстойг дурджээ:

- Итгэл нь хууль ёсных байх;
- Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь иргэн болон хуулийн этгээдэд эдийн буюу мөнгөн дүнгээр илэрхийлэх эрх зүйн үр дагавар үүссэн байх;
- Харин уг зарчим нь 48.2 дугаар заалтад тусгагдсан эерэг нөлөөлөл бүхий хууль бус захиргааны акт болох нь тогтоогдвол мөн иргэн, хуулийн этгээдэд эерэг үр дагавар үүсэхээр байсан ч уг харилцаа дууссан бол итгэл хамгаалах зарчим хэрэглэгдэхгүй байна.

Захиргааны ерөнхий хуульд энэхүү зарчмыг захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдэд материаллаг буюу мөнгөн дүнгээр

¹⁰ Даржаагийн Баттулга, "Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим", legaldata.mn, 2018, 2 дахь тал.

¹¹ Мөн тэнд, 2 дахь тал.

¹² Төрийн мэдээлэл эмхэтгэл, (2015) №28.

¹³ Тэрбишийн Мөнх-Эрдэнэ, Ганбаатарын Гэсэр, "Монгол Улсын захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим", legaldata.mn, 2019, 3 дахь тал.



илэрхийлэгдэх эрх зүйн үр дагавар үүссэн тохиолдлыг ойлгохоор тайлбарласан. Өөрөөр хэлбэл хувь хүнд эдийн засгийн материаллаг байдлаар эерэг, сөрөг үр дагавар хамаатай.¹⁴ Мөн итгэл хамгаалах зарчмыг захиргаанаас хэрэглэх нэг болзол нь иргэн, захиргааны хоорондын тухай харилцаа дуусаагүй байх ёстой. Иргэнд эерэг үр дагавар үүсгэхээр байсан ч гэсэн уг харилцаа хэдийн дууссан бол итгэл хамгаалах зарчмыг хэрэглэхгүй.¹⁵

Жишээлбэл, иргэний газар нь авто зам барих газарт орсон тул хашаа, байшингаа чөлөөлж өгөхийг Нийслэлийн Засаг даргаас шаардсан байна. Уг иргэнд өөр газар өгөх буюу мөнгөөр нөхөн олговор олгоно гэсэн тул уг иргэн газраа даруй өөрийн зардлаар чөлөөлжээ. Гэтэл Нийслэлийн Засаг даргаас авто замын хамрах газар өөрчлөгдсөн тул одоо танайх газраа чөлөөлөх шаардлагагүй болсон гэсэн байна. энэ жишээ бол иргэний хууль ёсны итгэл хамгаалагдах ёстой тохиолдол болно.¹⁶ Мөн хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг хэрэглэхгүй байх тохиолдлууд байна. Жишээ нь, тухайн иргэн өөхөө бусдыг залилах, хууран мэхлэх замаар, авлига өгөх зэрэг хууль бус үйлдлийн улмаас уг харилцааг үүсгэсэн бол тухайн иргэний итгэлийг хамгаалахгүй.¹⁷

Түүнчлэн, УДШ-ийн шүүгч Г.Банзрагч "Н" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт гаргасан тусгай саналдаа "хууль ёсны итгэлийг хамгаалах" зарчмыг дараах байдлаар тайлбарласан байна.

"Эрх зүйт ёс"-ны дагуу эдийн засгийн хүрээн дэх төрийн /захиргааны/ үйл ажиллагаа дараах шалгуурыг хангах ёстой гэж үздэг. Үүнд:

- төрийн үйл ажиллагаа хууль ёсны байх /хуульд үндэслэх, хуульд нийцэх/,
- эдийн засгийн хүрээн дэх төрийн үйл ажиллагаа нь урьдчилан тооцоолох буюу урьдаас харах бололцоотой байх,
- эдийн засгийн хүрээн дэх төрийн үйл ажиллагаа тодорхой байх,
- эдийн засгийн хүрээн дэх төрийн үйл ажиллагаа харьцангуй байх,
- эдийн засгийн хүрээн дэх төрийн /захиргааны/ хууль бус үйл ажиллагааны эсрэг эрх зүйн хамгаалалт байх гэх мэт.

Дээрх зарчмуудаас манай Захиргааны ерөнхий хуульд шууд болон дамжмал байдлаар зохицуулагдсан захиргааны үйл ажиллагаа "зорилгодоо нийцсэн, ... байх"; "хууль ёсны итгэлийг хамгаалах" гэсэн тусгай зарчмыг агуулсан хоёр шалгуурын талаар дэлгэрүүлэн авч үзвэл.

Эхнийх нь "эдийн засгийн хүрээн дэх төрийн үйл ажиллагаа харьцангуй байх" шалгуур юм. Энэ нь захиргааны үйл ажиллагааны зорилго, түүнд хүрэх арга хэрэгсэл болон зорилго, арга хэрэгслийн уялдаа холбоогоор тайлбарлагдана. Тодруулбал, захиргааны үйл ажиллагааны зорилго болон түүнд хүрэх арга хэрэгсэл нь хууль ёсны байхаас гадна зорилгод хүрэх арга хэрэгсэл нь

¹⁴ Даржаагийн Баттулга, "Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим", legaldata.mn, 2018, 3 дахь тал.

¹⁵ ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, "Эрх зүйн боловсрол" академи, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, 2017 анхны хэвлэл, УБ, 68 дахь тал.

¹⁶ Мөн тэнд, 69 дэх тал.

¹⁷ Мөн тэнд.



"харьцангуй" буюу тохиромжтой, зайлшгүй шаардлагатай, зохистой байх ёстой гэсэн үг юм.

Дараагийн шалгуур нь "эдийн засгийн хүрээн дэх төрийн буюу захиргааны үйл ажиллагаа урьдчилан тооцоолох буюу урьдаас харах боломжтой байх" юм. Үүний агуулга нь эдийн засгийн харилцааг зохицуулсан төрийн үйл ажиллагааны талаар, тухайлбал хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны актын талаар холбогдох этгээдүүд мэдсэн байх /хууль, хэм хэмжээний актыг албан ёсоор нийтэлсэн/ бөгөөд тэдэнд тухайн шийдвэрт нийцүүлэн өөрсдийн үйл ажиллагаагаа зохицуулах, дасан зохицох боломжит хугацаа олгосон байхыг ойлгодог. Энэхүү зарчим нь эдийн засгийн харилцаанд оролцож буй этгээдүүд нь төрийн үйл ажиллагаанд буюу хууль тогтоогчийн тогтоосон хуульд, захиргааны гаргасан шийдвэрт хэр хэмжээгээр итгэж болох тухай асуудалтай холбогддог. Эдийн засгийн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээд нь төрийн хууль тогтоомж, шийдвэрт итгэсний үндсэн дээр хөрөнгө оруулалт, худалдан авалт хийх, үйл ажиллагаагаа өргөтгөх, төлөвлөх зэргээр тодорхой хэмжээний зарлага гаргадаг, иймд энэхүү иргэдийн "итгэл хамгаалагдах" ёстой гэж үздэг. Гэхдээ нөгөө талаас төрийн үйл ажиллагааны зайлшгүй өөрчлөлтийг харгалзах учиртай. Өөрөөр хэлбэл, иргэд төрийн хууль тогтоомж, захиргааны шийдвэр хэзээ ч өөрчлөгдөхгүй гэж итгэх учиргүй юм. Иймээс төрийн үйл ажиллагаа тооцоолох боломжтой байна гэдэг нь нэг талаас төрийн үйл ажиллагаанд /шийдвэрт/ итгэсэн иргэдийн "итгэл хамгаалах" асуудал, нөгөө талаас хууль тогтоомжийг өөрчлөх зайлшгүй хэрэгцээ, шаардлага, тухайлбал, нийтийн ашиг сонирхлын асуудал яригддаг /нийт эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө, эсхүл нийтийн эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зайлшгүй шаардлага гэх мэт/. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн харилцаанд оролцогчдын хувьд хууль тогтоомж "сөргөөр" өөрчлөгдсөн тохиолдолд иргэдийн итгэл хамгаалагдах зарчим ямар тохиолдолд хэрэгжих /онцгой нөхцөл байдал бий болсон эсэх/, түүний хүрээ, хязгаарын асуудал яригдана гэсэн үг юм¹⁸ гэжээ.

Нэгтгэн дүгнэхэд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд үндэслэн хохирол амссан, материаллаг үүрэг хүлээсэн иргэн, хуулийн этгээдийг хамгаалах зорилготой бөгөөд захиргааны байгууллагын тогтвортой, шударга үйл ажиллагааг хангах чухал механизм юм. Гэхдээ энэ хамгаалалт нь хязгаартай бөгөөд төрийн үйл ажиллагааны зайлшгүй өөрчлөлтийг харгалзах учиртай, харин хууль бус оролдлого, ашиг сонирхлын зөрчил, эсхүл харилцаа дууссан нөхцөлд үйлчлэхгүй.

Иймд хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь иргэн захиргааны харилцаанд шударга ёсыг хангах, захиргааны байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх, мөн иргэн өөрийн хуульд нийцсэн үйл ажиллагаагаа итгэлтэйгээр явуулах нөхцөлийг баталгаажуулах ач холбогдолтой юм.

¹⁸ УДШ-ийн Захиргааны хэргийн шүүх хуралдааны тусгай санал, "Н" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт, <https://www.supremecourt.mn/mn/printa?id=14014&tp=2&s=5Z>, (Сүүлд үзсэн: 2025.12.15).



3.2. Шүүхийн практик

Дүн шинжилгээний энэхүү хэсэгт УДШ-ээс газрын эзэмшил, ашиглалттай холбоотой маргааныг "хууль ёсны итгэлийг хамгаалах" зарчимтай холбон тайлбарлан шийдвэрлэсэн ижил, төсөөтэй шүүхийн шийдвэрүүдийг дэлгэрүүлэн судалсан болно.

Дүн шинжилгээ хийж буй шүүхийн шийдвэрийн маргааны үйл баримттай ижил төсөөтэй шүүхийн шийдвэрийг shuukh.mn цахим хуудаснаас 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 10 сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд УДШ-ээр шийдвэрлэгдсэн нийт тогтоолуудаас газрын маргааны төрлөөр, "итгэл хамгаалах", "4.2.8" гэх түлхүүр үгээр хайлт хийж үзэхэд дүн шинжилгээнд хамааралтай УДШ-ийн 5 тогтоол байна.

Эдгээрээс 3 тохиолдолд нэхэмжлэгч, гуравдагч этгээд нарт "хууль ёсны итгэлийг хамгаалах" зарчим үйлчилнэ гэж үзсэн бол үлдэх 2 тохиолдолд уг зарчмыг хэрэглэхгүй гэж үзсэн байна. Эдгээрээс хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг баримтлан хэргийг хянан шийдвэрлэсэн 3 тохиолдлыг энэхүү хэсэгт дэлгэрүүлэн авч үзлээ.

1. ТЗҮЭГ, ТӨБЗГ-ын нэхэмжлэлтэй, нийслэлийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэг (гуравдагч этгээдийн хууль ёсны итгэлийг хамгаалсан)¹⁹

Хэргийн үйл баримт: Төрийн өмчийн хорооны 2000 оны 451 дүгээр тогтоолын дагуу иргэн Д.Б нь үл хөдлөх эд хөрөнгө хувьчлан авсан тухай баримт бүрдүүлэн газар эзэмших хүсэлт гаргасныг үндэслэн "ЦБ" ХХК-д 11290 мкв газрын эрхийг баталгаажуулсан. Нийслэлийн Засаг дарга 2002 оны А/565 дугаар захирамжаар ТЗҮЭГ-т 14835 мкв газар, "ЦБ" ХХК-д 11290 мкв газрыг агуулах, аж ахуйн зориулалтаар ашиглах эрхийг тус тус олгосон, 2014 оны А/919 дүгээр захирамжийн холбогдох хэсгээр "БП" ХХК-д "ММ" ХХК ("ЦБ" ХХК)-ийн эзэмшлийн 11290 мкв газрыг агуулах, аж ахуйн зориулалтаар шилжүүлсэн байна.

Нэхэмжлэлийн шаардлага: Нийслэлийн Засаг даргын 2002 оны А/565 дугаар захирамжийн "ЦБ" ХХК, ТЗҮЭГ-т холбогдох хэсгийг тус тус илт хууль бус захиргааны акт болохыг тогтоолгох, 2014 оны А/919 дүгээр захирамжийн "БП" ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах.

Анхан шатны шүүхийн шийдвэр: нэхэмжлэгч нь маргаан бүхий газрыг хоёр хувааж салган газар эзэмших эрхээ баталгаажуулахдаа 14835 мкв гэдгийг мэдэж, хүлээн зөвшөөрөн хүсэлт гаргаж, холбогдох материалыг хариуцагчид бүрдүүлэн өгсөн, маргаагүй. (6.1) Мөн гуравдагч этгээдэд газар эзэмших эрх шилжихээс өмнө шүүхэд хандах эрх нь нээлттэй байсан, энэ эрхээ хэрэгжүүлээгүй гээд нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон. (6.3)

Давж заалдах шатны шүүхийн магадлал: 2002 оны 565 дугаар захирамжийн холбогдох хэсэг нь Төрийн өмчийн хорооны тогтоол, худалдах худалдан авах

¹⁹ УДШ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 001/ХТ2024/0007 тогтоол, https://shuukh.mn/single_case/3210?daterange=2024-01-01%20-%202024-12-31&id=3&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2025.12.05).

гэрээнд тусгагдаагүй газрыг ашиглуулахаар шийдвэрлэсэн нь илт хууль бус захиргааны акт байх тул гарсан цагаасаа эхлэн эрх зүйн үйлчлэлгүй гэж үзэн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн. (7.1)

Хяналтын шатны шүүхийн тогтоол: Төрийн өмчийн хорооноос зохион байгуулсан дуудлага худалдаагаар худалдан авсан үл хөдлөх хөрөнгийг дагаж, түүний доорх газар болон орж гарах гарцыг баталгаажуулах зорилгоор, маргаан бүхий акт гарсан байх тул "төрийн өмчийн газрыг хууль бусаар шилжүүлсэн" гэх үндэслэл тогтоогдохгүй байна. (19)

Маргаан бүхий актын хувьд хариуцагч хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд нэхэмжлэгч Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар болон "ЦБ" ХХК-ийн хүсэлт, холбогдох баримтыг үндэслэн тус бүрт нь газар ашиглах эрхийг олгосон. (20)

Давж заалдах шатны шүүхээс "2002 оны 565 дугаар захирамжийн холбогдох хэсэг нь Төрийн өмчийн хорооны тогтоол, худалдах худалдан авах гэрээнд тусгагдаагүй газрыг ашиглуулахаар шийдвэрлэсэн нь илт хууль бус захиргааны акт байх тул гарсан цагаасаа эхлэн эрх зүйн үйлчлэлгүй" гэж дүгнэсэн нь буруу. (21)

Нэхэмжлэгч нь одоо эзэмшиж буй газрын хэмжээгээ тухайн цаг үедээ өөрөө хүлээн зөвшөөрч ашиглах эрхээ баталгаажуулж байсан, мөн гуравдагч этгээдийн газар эзэмших эрхийг эс зөвшөөрсөн бол хуульд заасан хугацаанд (шүүхийн журмаар) маргах боломжтой байтал маргалгүй 20 жил өнгөрсөн байх тул гуравдагч этгээдийн хувьд итгэл хамгаалагдах зарчим үйлчилнэ. Иймд холбогдох шаардлагыг хэрэгсэхгүй болгосон анхан шатны шүүхийн дүгнэлт үндэслэл бүхий байна. (27)

2. Монгол Оросын ХНН УБТЗ-ын нэхэмжлэлтэй, нийслэлийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэг (гуравдагч этгээдийн хууль ёсны итгэлийг хамгаалсан)²⁰

Хэргийн үйл баримт: иргэн Я.С нь УБТЗ-ын цаашид ашиглах боломжгүй гэж, үндсэн хөрөнгөөс хасагдсан гарааш, засварын газрын байрыг худалдан авч, улмаар нийслэлийн Засаг даргын 1998 оны А/152 өдрийн захирамжаар 300 мкв газар эзэмших эрхтэй болсон, 2008 онд Г.Ц нараас "газар давхацсан" гэж шүүхэд маргаан үүсгэсний дараа нийслэлийн Засаг даргын 2011 оны 951 дүгээр захирамжаар газрын байршлыг өөрчилж, хэмжээг нэмэгдүүлж, Баянгол дүүргийн 4 дүгээр хороонд, 1000 мкв газрыг үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлсэн, 2012 онд "Э" ХХК-д шилжүүлсэн. Мөн нийслэлийн Засаг даргын 2018 оны А/100 дугаар захирамж нь "Э" ХХК-ийн газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгасан байна.

Нэхэмжлэлийн шаардлага: Нийслэлийн Засаг даргын 2018 А/100 дугаартай захирамжийн "Э" ХХК-д холбогдох хэсгийг илт хууль бус болохыг тогтоолгох, Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 162 дугаар захирамж, Засгийн газрын

²⁰ УДШ-ийн 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 001/ХТ2023/0081 торгоол, https://shuukh.mn/single_case/3179?daterange=2023-01-01%20-%202023-12-31&id=3&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2025.12.05).



2021 оны хуралдааны 55 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлэхгүй байгаа эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоолгож, "УБТЗ" ХНН-д газар ашиглах эрхийг зохих журмын дагуу олгохыг даалгах.

Анхан шатны шүүхийн шийдвэр: "УБТЗ" ХНН-т маргаан бүхий газрыг эзэмшүүлсэн эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр гараагүй, түүний эдэлбэр газраар бүртгээгүй байхад БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1949 оны болон 1952 оны хэлэлцээрийн дагуу газрыг эзэмшүүлэх ёстой гэж үзэх үндэслэлгүй, газраа Газрын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу баталгаажуулах учиртай. (6.1)

Нэхэмжлэгчийн хүсэл зоригийн дагуу иргэн Я.С нь газар, түүн дээр байрлах үл хөдлөх хөрөнгийг худалдаж авсан, улмаар тэдгээрийн хүсэлтээр байршлыг өөрчилсөн, маргаан бүхий газарт түрүүлж хүсэлт гаргаж, холбогдох баримтаа бүрдүүлэн өгсөн. (6.2)

Засгийн газрын ... үүрэг чиглэлийн дагуу нийслэлийн Засаг дарга нь 2021 оны А/823 дугаар захирамжаар УБТЗ-ын барилга, байгууламж бүхий нийслэлийн нутаг дэвсгэр дэх 49 нэгж талбар газраас эхний ээлжид 19 нэгж талбар бүхий газрын ашиглах эрхийг олгосон, "Э" ХХК-д газар эзэмшүүлсэн захирамжийг хүчингүй болгохыг, мөн нэхэмжлэгчид олгож баталгаажуулахыг даалгасан, чиглэл өгсөн зүйл огт дурдаагүй гээд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. (6.3)

Давж заалдах шатны шүүхийн магадлал: "УБТЗ" ХНН нь ашиглах эрх олгогдсон газраа Газрын тухай хуульд заасан журмын дагуу баталгаажуулах зорилгоор 2006 оноос хойш нийслэлийн Засаг даргад хандан хүсэлт гаргаж байсан, (7.1) иргэн Я.С-оос гаргасан хуульд заасан шаардлага хангаагүй хүсэлтийг үндэслэн маргаан бүхий газрыг эзэмшүүлж шийдвэрлэснийг эрх зүйн үндэслэлгүй буюу Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д заасан илт хууль бус захиргааны акт гэж үзэн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн. (7.2)

Хяналтын шатны шүүхийн тогтоол: УДШ-ийн 2010 оны 111 дүгээр тогтоолд "... "УБТЗ" нийгэмлэг нь 1994, 2002 оны Газрын тухай хууль, 1996 оны ТЗ-ын тээврийн аюулгүй байдлын тухай болон 2007 оны Төмөр замын тээврийн тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу газраа баталгаажуулж аваагүйгээс маргаан бүхий газрын хуульд заасан журмын дагуу эзэмшигч гэж үзэх үндэслэлгүй" гэж дүгнэж байсан, нэхэмжлэгчийн "газар баталгаажуулж авах" тухай хүсэлтэд захиргааны байгууллагаас "судалж байна" гэж хариу өгч байсан боловч шийдээгүй буюу захиргааны байгууллагын эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоолгохоор шүүхэд маргаж байгаагүй, 2014 оноос хойш газраа баталгаажуулаагүй нэхэмжлэгчийн үйлдлийг зөвтгөх хууль зүйн үндэслэл байхгүй тул нэхэмжлэгчийн "газраа баталгаажуулж авахаар удаа дараа хүсэлт гаргасан боловч захиргаа шийдэж өгөөгүй" гэх тайлбараар нэхэмжлэлийг хангах боломжгүй. (12)

Нэхэмжлэгч уг захирамжийг мэдсэнээс хойш эрхээ хамгаалж, хуулийн хугацаанд нэхэмжлэл гаргаагүй, хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн, тухайн асуудлаар маргах эрхээ алджээ. (14)

Нэхэмжлэгчээс "маргаан бүхий газар нь төмөр замын эзэмшил ашиглалтад хугацаагүй шилжсэн газар" гэж маргаж байгаа боловч үүнийг нотолсон баримт байхгүй, эрх бүхий байгууллагын газар олгосон шийдвэр гараагүй, харин нэхэмжлэгч хуулийн этгээдийн дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой буюу нэхэмжлэгч хуулийн этгээд нь өөрсдөө газраа бусдад шилжүүлснээр гуравдагч этгээдэд газар эзэмших эрх үүссэн тул гуравдагч этгээдийн хувьд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.8-д заасан итгэл хамгаалах зарчим үйлчлэх ... (16)

Мөн нэхэмжлэгчийн илт хууль бус болохыг тогтоолгохыг хүссэн нийслэлийн Засаг даргын 2018 оны А/100 дугаар захирамж нь "Э" ХХК-ийн газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгасан буюу иргэн Я.С-ын хүсэлтийн дагуу "Э" ХХК-д шилжүүлсэн нийслэлийн Засаг даргын 2012 оны А/445 дугаар захирамжийг үндэслэн гарсан байх тул өмнөх захирамжаас тусад нь салгаж дүгнэх боломжгүй. (17)

3. Х.М-ийн нэхэмжлэлтэй, нийслэлийн ЗД, БЗД-ийн ЗД, Баянзүрх дүүргийн Газар зохион байгуулалтын албанд тус тус холбогдох захиргааны хэрэг (нэхэмжлэгчийн хууль ёсны итгэлийг хамгаалсан)²¹

Хэргийн үйл баримт: Баянзүрх дүүргийн Засаг даргын 2007 оны 299 дүгээр захирамжаар "Ф М" ТББ-ын эзэмшиж байсан 100,000 м.кв газраас 30,000 м.кв газрыг М.Т-нд эзэмшүүлэхээр шилжүүлсэн, 2013 оны А/516 дугаар захирамжаар М.Т-ийн газар эзэмших эрхийн хугацааг 5 жилээр сунгасан, улмаар 2014 оны А/115 дугаар захирамжаар уг газрыг нэхэмжлэгч Х.М-д шилжүүлсэн, харин энэ хооронд буюу 2010 онд Нийслэлийн Засаг даргын 703 дугаар захирамжаар "Ундны усны тэжээлийн дотоод мужид газар эзэмших эрх олгосон" гэсэн үндэслэлээр М.Т-ийн газар эзэмших эрхийг хүчингүй болгосон байжээ.

Нэхэмжлэлийн шаардлага: Нийслэлийн Засаг даргын 2010 оны 703 дугаар захирамжийн М.Т-нд холбогдох хэсгийн Туул голын усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсэд хамаарахгүй хэсгийг хүчингүй болгуулах, "А" ХХК-ийн үйлдсэн 2007 оны М.Т-ийн кадастрын зургаас усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсэд хамаарах хэсгийг хасаж, үлдсэн хэмжээгээр Х.М-ийн нэр дээр газрын кадастрын мэдээллийн санд бүртгэхийг Баянзүрх дүүргийн Газар зохион байгуулалтын албанд даалгуулах, Х.М-ийн эзэмшлийн 30,000 м.кв газраас Туул голын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд ороогүй хэсгээр эзэмших эрхийг сэргээсэн захирамж гаргахыг Баянзүрх дүүргийн Засаг даргад даалгуулах.

Анхан шатны шүүхийн шийдвэр: Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.8-д заасныг баримтлан нэхэмжлэгч Х.М-ийн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэхдээ нэхэмжлэгч нь өөрийн эзэмшлийн газрын төлбөрийг Газрын тухай хууль болон Баянзүрх дүүргийн Газрын албатай 2014 онд байгуулсан Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээний дагуу 30,000 м.кв-аар төлж ирсэн болох нь төлбөрийн баримтуудаар

²¹ УДШ-ийн 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 001/ХТ2021/0070 торгоол, https://shuukh.mn/single_case/2733?daterange=2021-01-01%20-%202021-12-31&id=3&court_cat=3&bb=1, (Сүүлд үзсэн: 2025.12.05).



тогтоогдож байна. Иймээс нэхэмжлэгчид хууль ёсны итгэл бий болсон, захиргааны үйл ажиллагаанд баримтлах хууль ёсны итгэл хамгаалах зарчим зөрчигдсөн гэж үзэхээр байна гэжээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлал: Хэрэгт хамаарал бүхий нөхцөл байдлыг бүрэн тодруулаагүйн улмаас давж заалдах шатны шүүхээс хэрэгт авагдсан баримтын хүрээнд нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, хэргийн нөхцөл байдалд дүгнэлт өгч, хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй гэж үзэн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүхийн тогтоол: Хариуцагч Баянзүрх дүүргийн Засаг даргаас "2010 оны нийслэлийн Засаг даргын 703 дугаар захирамжаар нэхэмжлэгч Х.М-д шилжүүлсэн 30,000 м.кв бүхий талбайг иргэн М.Т-ийн эзэмшилд байх үед хүчингүй болгосон, иймд дүүргийн Засаг даргын /өөрийнх нь/ сүүлд гаргасан М.Т-ийн газар эзэмших эрхийн хугацааг сунгасан, нэхэмжлэгчид шилжүүлсэн захирамжууд хууль бус, маргаан бүхий газар нь одоо сул чөлөөтэй, уг газрыг эзэмшихээр гуравдагч этгээд нар хүсэлтээ гаргасан байгаа..." гэсэн агуулгатай тайлбар үндэслэлгүй. (25)

Учир нь, анхан шатны шүүхийн дүгнэсэнчлэн, хариуцагч Баянзүрх дүүргийн Засаг дарга 2013 оны А/516 дугаар захирамжаар М.Т-ийн газар эзэмших эрхийг сунгахдаа, мөн 2014 оны А/115 дугаар захирамжаар уг газрыг нэхэмжлэгчид шилжүүлэхдээ тухайн газар эзэмших эрх нь хүчинтэй эсэхийг /Нийслэлийн Засаг даргын захирамж гарсныг/ шалгах үүрэгтэй байсан ч уг үүргээ биелүүлээгүйд нэхэмжлэгчийг буруутгах үндэслэлгүй, нэхэмжлэгчид газар эзэмших эрх олгосон буюу шилжүүлсэн 2015 оны А/115 дугаар захирамж одоо ч хүчин төгөлдөр буюу хариуцагчийн хэн аль нь уг захирамжийг хүчингүй болгоогүй, нэхэмжлэгчийн итгэл хамгаалагдсан байна.

Дүн шинжилгээ: Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь гуравдагч этгээд, нэхэмжлэгчид ч адил тэгш үйлчлэх ба захиргааны байгууллагын алдаатай, эсхүл өөрийн шийдвэрийг үгүйсгэсэн үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэрэгсэл болон хэрэгжиж буйг харж болохоор байна.

Эхний хоёр тохиолдолд шүүхээс дүгнэхдээ захиргааны байгууллага хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд захиргааны акт гаргасан ба нэхэмжлэгч тухайн актыг хүлээн зөвшөөрч, хууль ёсны байдалд маргаан үүсгэн хүчингүй болгуулахаар эрх бүхий албан тушаалтан, шүүхэд хандаж байгаагүй хэр нь удаан хугацааны дараа уг актыг хүчингүй болгуулахаар маргаж байгаа нь эрх зүйн тогтвортой байдал, хууль зүйн үүднээс зөвтгөгдөхгүй болохыг тайлбарласан байна.

Иймээс "УБТЗ" ХНН-ийн тухайд өөрийн шийдвэрийн үндсэн дээр эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр гуравдагч этгээдэд шилжсэн газрыг эргүүлэн буцаан шаардах нь захиргааны байгууллагын шийдвэрийн хууль ёсны байдалд итгэж, санхүүгийн хувьд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийж, эрсдэл үүрч тухайн газар дээр олон жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулсан



хуулийн этгээдийн хууль ёсны итгэл, эдийн засгийн ашиг сонирхлыг илтэд зөрчсөн явдал болно.

Харин гурав дахь тохиолдолд захиргааны байгууллагын алдаатай үйл ажиллагаа нь өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан захиргааны актын хууль ёсны байдал, хүчин төгөлдөр эсэхийг хянан шалгаж, зохих журмын дагуу хүчингүй болголгүйгээр өөр этгээдэд ижил агуулгатай эрх үүсгэснээр эрх зүйн тодорхойгүй байдал, зөрчил бий болгож байгаагаар илэрч байна. Ийм нөхцөлд захиргааны байгууллагын хууль бус, алдаатай шийдвэр, үйл ажиллагааны улмаас гарах сөрөг үр дагаврыг иргэн, хуулийн этгээдэд хариуцуулан, тэдний хууль ёсны итгэлд тулгуурласан эрх, ашиг сонирхлыг хохироох нь өмнөх хэсэгт дүгнэсэн захиргааны байгууллагын хариуцлагатай, тогтвортой, шударгаар үйл ажиллагаа явуулах үүрэгтэй нь илтэд зөрчилдөх юм.

Дүн шинжилгээ хийж буй шүүхийн шийдвэрийн тухайд хяналтын шатны шүүхээс захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх, түүний улмаас иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны итгэлд суурилсан эрх, ашиг сонирхол хөндөгдсөн бол Захиргааны ерөнхий хуулийн 104 дүгээр зүйлд заасан нөхөн олговор шаардан маргах эрхийг хааж болохгүй гэсэн дүгнэлтийг хийсэн байна. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага үүссэн нөхцөл байдлыг бүхэлд нь иргэн, хуулийн этгээдэд үүрүүлээд дуусгах бус өмнөх болон сүүлд гаргасан маргаан бүхий шийдвэрийнхээ хүрээнд хариуцлага үүрч хохирол, нөхөн олговрын асуудлыг хүлээн авч шийдвэрлэх нь иргэд төрийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна.

3.3. Гадаад улсын эрх зүйн зохицуулалт

3.3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид "ХБНГУ" гэх)-ын 1976 онд баталсан Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар *"Нэг удаагийн, эсхүл үргэлжилсэн мөнгөн төлбөр, эсхүл хувааж болох эд материалын ашиг олгох эрх зүйн үндсэн болсон хууль бус захиргааны актыг, ашиг хүртэгч нь тухайн захиргааны акт хүчинтэй хэвээр байгаа гэж итгэн найдсан бөгөөд түүний энэхүү итгэл нь уг актыг буцаан хүчингүй болгохтой холбоотой нийтийн ашиг сонирхлоос давуу, хамгаалагдах үндэслэлтэй гэж үнэлэгдсэн тохиолдолд буцаан хүчингүй болгохгүй."* хэмээн хүн, хуулийн этгээдийн хууль ёсны итгэлийг хамгаалсан эрх зүйн зохицуулалтыг тусгажээ.²²

Энэхүү "Хууль ёсны итгэл" гэх ойлголтын онцлог шинж чанар нь зөвхөн хууль эрх зүйн аюулгүй байдлын зарчим төдийгүй хүний үндсэн эрхээс үүдэлтэй гэж тайлбарласан байдаг.²³ Дэлхийн 2 дугаар дайныг дуустал ХБНГУ-ын захиргааны эрх зүйд хууль ёсны итгэлийг маш хязгаарлагдмал хүрээнд хамгаалж байв. Захиргааны актыг хүчингүй болгохыг хориглосон цорын ганц тохиолдол нь тухайн акт хууль ёсны бөгөөд ашиг хүртэгч нь түүнд итгэн тодорхой үйлдэл хийж

²² Administrative Procedure Act (1976) §48(2).

²³ Georg Nilte, "General Principles of German and European Administrative Law – A Comparison in Historical Perspective", The Modern Law Review, 1994, Published by Blackwell Publishers, p.195.



эхэлсэн буюу барилгын зөвшөөрөл авсны дараа байшин барьж эхэлсэн нөхцөл байдал байв. Харин захиргааны акт хууль бус байсан тохиолдолд, ямар ч итгэл үүссэн эсэхээс үл хамааран хүчингүй болгодог.²⁴

Энэхүү байдал нь 1956 оны түүхэн ач холбогдол бүхий шүүхийн шийдвэрээр өөрчлөгджээ. Тухайлбал, Берлин хотын Захиргааны хэргийн шүүхээс "захиргааны байгууллагын хуульд захирагдах зарчим" нь хууль бус захиргааны актаас ашиг хүртсэн этгээдийн хууль ёсны итгэлтэй зөрчилдөж болзошгүйг хүлээн зөвшөөрсөн. Эдгээр зарчмууд хоёул Үндсэн хуулиар баталгаажсан тул шүүх тухайн тохиолдол бүрд жинлэн тэнцвэржүүлэх замаар шийдвэрлэх ёстой гэж дүгнэсэн байна.²⁵

Мөн ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн үзэж байгаагаар, аливаа этгээдийн итгэлд тулгуурласан ашиг сонирхол нь нэг талаас эрх зүйт төрийн зарчим, нөгөө талаас үйл ажиллагааны эрх чөлөөний ерөнхий зарчим (Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)-аар хамгаалагддаг. Иймд Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн 48, 49 дүгээр зүйлүүдэд тусгагдсан ижил төстэй, харилцан уялдаа бүхий зохицуулалтууд нь үндсэндээ "Үндсэн хуулийн хэм хэмжээг тодорхой болгож хэрэгжүүлсэн хэлбэр" хэмээн бичжээ.²⁶

Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 2 дахь хэсгээс харвал хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим дараах нөхцөлүүд хангагдсан тохиолдолд үйлчлэхээр байна. Үүнд:

- Хүн, хуулийн этгээд тухайн захиргааны актын үйлчлэлээс хамааран аливаа ашиг олсон;
- Захиргааны акт хүчинтэй хэвээр байгаа гэж итгэн тодорхой үйлдэл (зардал) хийсэн;
- Захиргааны актыг хүчингүй болгохтой холбоотой нийтийн ашиг сонирхлоос илүүтэйгээр тухайн этгээдийн итгэлийг хамгаалах нь эрх зүйн ач холбогдолтой бол.

Харин тухайн этгээд залилах, дарамтлах, авлига өгөх замаар захиргааны актыг гаргуулсан, буруу, эсхүл дутуу мэдээлэл өгсөн, захиргааны акт хууль бус гэдгийг мэдэж байсан, эсхүл хайхрамжгүйгээс болж мэдээгүй тохиолдлуудад хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим үйлчлэхгүй байна.

3.3.2. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (цаашид "Их Британи" гэх)-д хууль ёсны итгэл гэх хэллэг нь 1969 онд нэвтэрсэн. Гэсэн хэдий ч олон жилийн турш хөгжөөгүй хэвээр байсан бөгөөд зөвхөн 1980-аад онд бүрэн хүлээн зөвшөөрөгдөж, боловсруулагдсан байдаг. Их Британид захиргааны эрх зүйн ерөнхий болон процессын хууль тогтоомж байдаггүй ч шүүхүүд процессын шударга ёс, үндэслэл бүхий байдал, пропорциональ байдал, хууль ёсны итгэл зэрэг захиргааны эрх зүйн ерөнхий зарчмуудыг боловсруулсан байдаг.²⁷

²⁴ Ibid, 203.

²⁵ Ibid.

²⁶ Ibid.

²⁷ Robert Thomas, "The Protection of Legitimate Expectations in UK Administrative Law", 2012, p.6.

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим процессын болон бодит гэсэн 2 хүрээнд яригддаг ба үүнийг дараах байдлаар тодорхойлжээ. "Уг зарчим анхлан зөвхөн процессын хүрээнд хэрэглэгдэж байв. Процессын хууль ёсны итгэл (англ. procedural expectations)-ийн сонгодог жишээ нь захиргааны байгууллага тодорхой шийдвэр гаргахаасаа өмнө зарим этгээдийг заавал сонсох, эсхүл тэдэнтэй зөвлөлдөх тухай тодорхой, хоёрдмол утгагүй баталгаа өгсөн тохиолдол юм. Ийм баталгаа нь ил тод амлалт хэлбэрээр ч, эсхүл тогтсон жишиг, практик хэлбэрээр ч илэрч болно. Процессын хууль ёсны итгэлтэй холбоотой шүүхийн хяналт нь харьцангуй асуудал багатайд тооцогддог. Учир нь шүүх захиргааны байгууллагыг тодорхой агуулгатай шийдвэр гаргахыг тулган шаардаж байгаа бус, харин шийдвэр гаргахаасаа өмнө зөвлөлдөх, эсхүл сонсгол явуулах процессын үүргээ биелүүлэхийг шаардаж буй хэрэг юм."²⁸

"Харин бодит хууль ёсны итгэл (англ. substantive legitimate expectations) нь захиргааны байгууллага тодорхой бодлого, албан ёсны мэдэгдэл, амлалтынхаа дагуу материаллаг шинжтэй асуудлаар үйл ажиллагаа явуулна гэсэн хүлээлт үүссэн тохиолдолд бий болдог. Өөрөө хэлбэл, тухайн этгээд тодорхой бодит ашиг, эрх, давуу байдал олж авна гэсэн хүлээлт тогтсон байхыг хэлнэ" хэмээн бичжээ.²⁹ Энэхүү 2 дахь ойлголт Монгол Улсын практикт тогтсон хууль ёсны итгэлийг хамгаалах зарчимтай илүү нийцэж байна гэж дүгнэж болохоор байна.

Энэхүү бодит хууль ёсны итгэлийн онолыг хөгжихөд Кофлан (англ. Coughlan)-ны хэрэг чухал нөлөө үзүүлсэн юм. Учир нь уг хэргээс өмнө уг онол Их Британийн эрх зүйд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн байсан эсэх нь тодорхой бус байв.

Энэхүү хэргийн үйл баримтыг товч дурдвал:³⁰ Хатагтай Кофлан нь дөрвөн мөчний саажилттай бөгөөд 1971–1993 оны хооронд архаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан Newcourt нэртэй эмнэлэгт амьдарч байжээ. Уг эмнэлгийг орчин үеийн стандартад тохиромжгүй гэж үзэн өвчтөнүүдийг 1993 онд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусгайлан зориулж барьсан шинэ Mardon House хэмээх эмнэлэгт шилжүүлсэн байна. Mardon House-д нүүж орсон хатагтай Кофлан болон бусад оршин суугчдад уг эмнэлгийн байранд насан туршид нь амьдруулна гэсэн баталгааг өгсөн байв. Гэвч 1998 онд уг байгууламжийг хариуцаж байсан Эрүүл мэндийн байгууллага тус байрыг "хэт өндөр зардалтай, санхүүгийн хувьд тогтвортой бус, бусад үйлчилгээний нөөцийг багасгаж байна" гэсэн үндэслэлээр хаахаар шийдвэрлэжээ.

Үүний улмаас хатагтай Кофлан болон бусад оршин суугчдыг тэдний хэрэгцээнд тусгайлан бариагүй, орон нутгийн захиргааны харьяа асрамжийн байранд шилжүүлэхээр болсон байна. Үүнийг эсэргүүцэн хатагтай Кофлан шүүхэд хандаж, Эрүүл мэндийн байгууллага нь өвчтөнүүдэд өгсөн амлалтаа зөрчиж, хууль бус шийдвэр гаргасан гэж маргажээ.

Шүүхээс хатагтай Кофландад Mardon house-д өөрийн хүссэн хугацаагаараа амьдрах хууль ёсны итгэл үүссэн байсан, улмаар Эрүүл мэндийн байгууллага

²⁸ Ibid, 11.

²⁹ Ibid, 6.

³⁰ Seemeen Muzafar, "Doctrine of Legitimate Expectation: A weapon against abuse of discretion and tool to secure accountability", ICRT Volume 6, Issue 1, 2018, p.181.



хатагтай Кофланы хууль ёсны итгэлийг зөрчсөн, эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан гэж дүгнэн нэхэмжлэгчийн талд шийдвэр гаргасан байдаг.

Их Британид хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь ХБНГУ-аас ялгаатай нь бичмэл хуульд бус, шүүхийн жишгээр хөгжиж ирсэн байна. Ингэхдээ шүүхээс хүн, хуулийн этгээдийн хууль ёсны итгэлийг хамгаалах үндэслэл бий эсэхийг тогтоохдоо захиргааны байгууллагын бодлого, шийдвэр, амлалт нь тухайн этгээдэд бодит ашиг, эрх, давуу байдал олж авах зүй ёсны итгэл үүсгэсэн эсэхийг шалган, улмаар захиргааны байгууллагын зорилго, бодлогын тэргүүлэх чиглэлийг харгалзан үзэхийн зэрэгцээ, нөгөө талаас нэхэмжлэгчийн эрхийг хамгаалах харьцааг тэнцвэржүүлэх зарчмын үндсэн дээр шийдвэрлэдэг³¹ хэмээн бичжээ. Харин эрх нь зөрчигдсөн гэх этгээдэд аливаа мөнгөн төлбөр, зардал зайлшгүй гаргасан байх шаардлагыг тавиагүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим нь захиргааны эрх зүйн маргаанд иргэний эрхийг бодитой хамгаалах, захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны хариуцлагыг нэмэгдүүлэх чухал үүрэгтэй. Монгол Улсын хувьд Захиргааны ерөнхий хуульд "захиргааны байгууллага нь үйл ажиллагаандаа хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмыг баримтална" хэмээн хуульчилж өгсөн байдаг. Уг зарчим нийтийн эрх зүйн харилцааны хүрээнд захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдэд эдийн буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эрх зүйн үр дагавар үүссэн тохиолдолд л хөндөгдөх юм. Гэхдээ хууль ёсны итгэл бий гэх үндэслэлээр ямар ч тохиолдолд давуу байдал олж авах эрхтэй гэж ойлгож болохгүй. Захиргааны ерөнхий хуульд зааснаар иргэн, хуулийн этгээд захиргааны актаар олгосон эрхийг хэрэгжүүлээгүй, захиргааны актыг хууль бус аргаар гаргуулсан, нийтийн ашиг сонирхолд харшилсан гэх нөхцөл байдал тогтоогдвол итгэл хамгаалагдахгүй. Мөн гадаад улсын зохицуулалт, шүүхийн жишгийн дагуу дээрх шаардлагууд мөн адил ижилхэн тавигддаг байна.

Дүн шинжилгээ хийсэн шүүхийн шийдвэрээс үзэхэд нэхэмжлэгч иргэн нь тухайн газар дээр олон жил үйл ажиллагаа явуулсан ч 2002 оны Газрын тухай хуульд заасан шаардлагын дагуу газрыг эзэмшээгүй тул өөрийн зөрчигдсөн эрхийг хамгаалах, хохирлоо нэхэмжлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн. Гэсэн хэдий ч нэхэмжлэгч 1999 оноос хойш газрыг бодитоор ашиглаж, жил бүр газрын төлбөрийг төлж ирсэн нь тогтоогдсон. Энэ тохиолдолд түүнд газрыг зохих ёсоор эзэмшиж байна гэсэн тодорхой итгэл үнэмшил бий болсон байдаг. Иймд хяналтын шатны шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, нэхэмжлэгч иргэнийг маргаан бүхий захирамжид холбогдуулан учирсан хохирол, нөхөн олговрын асуудлаар маргах эрхтэй гэж үзсэн. Түүнчлэн, шүүхийн практикаас харвал "итгэл хамгаалах зарчим" нь нэхэмжлэгчид төдийгүй гуравдагч этгээдэд адил эрх тэгш үйлчлэх ёстой байдаг байна.

Мөн судлаачдын тайлбараас үзвэл, "эрх зүйт ёс"-ны дагуу эдийн засгийн хүрээнд захиргааны үйл ажиллагааны "эдийн засгийн хүрээн дэх төрийн үйл

³¹ Ibid, 183.



ажиллагаа харьцангуй байх", "эдийн засгийн хүрээн дэх төрийн буюу захиргааны ажиллагаа урьдчилан тооцоолох буюу урьдаас харах боломжтой байх" шалгуурууд нь "хууль ёсны итгэлийг хамгаалах" зарчмыг агуулж байдаг гэжээ. Тухайлбал, захиргааны үйл ажиллагаа нөхцөл байдалд тохирсон, зайлшгүй байх шаардлагыг хангасан, зохистой хэмжээнд байх, мөн холбогдох этгээдүүдэд мэдэгдэж, тэдэнд өөрсдийн үйл ажиллагаагаа зохицуулах, дасан зохицох боломжит хугацаа олгосноор төрийн үйл ажиллагаанд итгэж тодорхой зардал гаргадаг учир иргэдийн "итгэл хамгаалагдах" ёстой байна. Энэхүү дүн шинжилгээ хийсэн шүүхийн шийдвэр нь захиргааны байгууллага өөрийн шийдвэр, үйл ажиллагааны үр нөлөөг урьдчилан тооцож бусад этгээдийн итгэлийг хохироохгүй байх үүрэг хүлээх ёстойг баталгаажуулснаараа чухал ач холбогдолтой юм

НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Захиргааны ерөнхий хууль, 2015 он.
2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он.
3. Газрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, 2002 он.
4. УДШ-ийн 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 0077 тогтоол.
5. УДШ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 001/ХТ2024/0007 тогтоол.
6. УДШ-ийн 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 001/ХТ2023/0081 тогтоол.
7. УДШ-ийн 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 001/ХТ2021/0070 тогтоол.
8. УДШ-ийн Захиргааны хэргийн шүүх хуралдааны тусгай санал, "Н" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт.
9. ЗХДЗШШ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 0242 магадлал.
10. НдЗХАШШ-ийн 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 0139 шийдвэр.
11. Administrative Procedure Act of Germany, 1976.

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, "Эрх зүйн боловсрол" академи, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, 2017 он.
2. Даржаагийн Баттулга, "Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим", legaldata.mn, 2018 он.
3. Тэрбишийн Мөнх-Эрдэнэ, Ганбаатарын Гэсэр, "Монгол Улсын захиргааны эрх зүй дэх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим", legaldata.mn, 2019 он.

3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. Georg Nilte, "General Principles of German and European Administrative Law – A Comparison in Historical Perspective", The Modern Law Review, 1994.
2. Robert Thomas, "The Protection of Legitimate Expectations in UK Administrative Law", 2012.
3. Seemeen Muzafar, "Doctrine of Legitimate Expectation: A weapon against abuse of discretion and tool to secure accountability", ICRT Volume 6, Issue 1, 2018.



4. Цахим эх сурвалж:

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn>.
2. Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан: <https://legaldata.mn/>.
3. Ном, сэтгүүл, судалгааны бүтээлийн цахим сан: <https://www.wiley.com/>.
4. Олон улсын IJCRT сэтгүүлийн цахим хуудас: <https://www.ijcrt.org/>.
5. Судалгааны бүтээлийн цахим сан: <https://www.researchgate.net/>.